МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ ИНЖЕНЕР
ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ШИНЭ ТЕХНОЛОГИ СУДЛАХ, ИННОВАЦИЙН ТУРШИЛТ СУДАЛГАА ХИЙХ

НБОГ/20250201017

Тайлан бичсэн:  профессор, др Ц.Соёл-Эрдэнэ

2025.08.30

АГУУЛГА

Хураангуй 4
Оршил 5
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ 8
1.1. Үндэслэл 8
1.1.1 Нөхцөл байдал, шаардлага 8
1.2 Эрх зүй, бодлогын үндэслэл 9
1.3. Цеолитийн тухай ерөнхий ойлголт 10
1.4. Гидротермал синтезийн арга 11
1.4.1. Шинжлэх ухааны үндэс: 12
1.4.2. Урвалын механизм ба нөхцөл: 12
1.4.3. Түүхий эдийн сонголт: 13
1.5. Хромын бохирдол ба түүнийг зайлуулах аргууд 13
1.6. Шахмал түлшний үнс 14
1.6.1. Үүсэл ба найрлага: 15
1.6.2. Байгаль орчинд үзүүлэх нөлөө: 15
1.6.3. Дахин ашиглах боломж: 16
1.7. Хөнгөн цагааны эх үүсвэрүүд 16
1.2 Ажлын зорилго, зорилт 17
1.2.1 Ажлын зорилтууд 17
1.7. Судлагдсан байдал 18
1.7.1. Шахмал нүүрсний үнсний бүтэц, экологийн эрсдэл 18
1.7.2. Нүүрсний үнснээс цеолит синтезлэх олон улсын туршлага: 19
1.7.3. Хром шингээхэд цеолит ашигласан судалгаанууд: 19
1.7.4. Монгол дахь холбогдох судалгааны сул орон зай: 20
ХОЁРДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ 21
2.1. Ашигласан материал 21
2.2. Цеолит синтезийн арга зүй 21
2.3. Хром шингээх туршилтын арга зүй 23
2.4. Шинжилгээний аргууд 24
ГУРАВДУГААР БҮЛЭГ: ҮР ДҮН, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ 25
3.1. Шахмал түлшний үнсний шинж чанар 25
3.2. Синтетик цеолитуудын эрдсийн найрлага (XRD шинжилгээ) 26
3.2.1. Үнсний XRD үр дүн: 26
3.2.2. Синтезлэгдсэн цеолитуудын XRD үр дүн: 26
3.2.3. Гарган авсан цеолитын XRD хамаарал: 27
3.3. Цеолитуудын хром шингээх чадвар 30
3.3.1. Анхдагч үнсний хром шингээх багтаамж: 30
3.3.2. Синтетик цеолитуудын хром шингээх багтаамжийн харьцуулалт: 30

3.3.3. Хром шингээлтийн кинетик ба изотерм 31
3.3.4. Үр дүнгүүдийн нэгтгэл ба хэлэлцүүлэг 32
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ХАЯГДЛЫГ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛГОХ, ХОРТ БОДИСЫГ САЛМАГЖУУЛАХ АРГА ЗҮЙ, УДИРДАМЖ 34
4.1. Хаягдлыг бүтээгдэхүүнээс шинэ материал гарган авах загвар 34
4.1.1. Загварын үндэслэл: Шахмал түлшний үнснээс цеолит гарган авах 34
4.1.2. Үйл ажиллагааны зарчим: 35
4.1.3. Үндэсний эрх зүй, бодлогын орчин 37
ТАВДУГААР БҮЛЭГ: БОДЛОГЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ 39
5.1. Хаягдлаас үнэ цэнэтэй бүтээгдэхүүн гарган авах боломж 39
5.1.1. Шахмал түлшний үнснээс цеолит гарган авах: 39
5.1.2. Хор нөлөөт бодисыг саармагжуулах арга зүй 39
5.2. Бодлогын зөвлөмж 40
Дүгнэлт 41
Ном Зүй 42


ХУРААНГУЙ

Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын гэр хорооллоос үүсэх шахмал түлшний үнсийг ашиглан синтетик цеолит гарган авах, мөн гарган авсан цеолитуудын уснаас хром (Cr) шингээх чадварыг судлах зорилготой судалгааны ажлын үр дүнг нэгтгэн танилцуулж байна. Судалгаанд шахмал түлшний үнс, нунтаг хөнгөн цагаан, болон хаягдал хөнгөн цагаан лаазыг түүхий эд болгон ашигласан. Цеолит синтезийн процессыг гидротермал аргаар гүйцэтгэсэн бөгөөд үнсний дээжинд XRF (X-ray Fluorescence) шинжилгээ, харин үнс болон синтезлэгдсэн цеолит дээжүүдэд XRD (X-ray Diffraction) шинжилгээ хийж, эрдсийн найрлагын өөрчлөлтийг тодорхойлсон.

Үр дүнгээс харахад, шахмал түлшний үнснээс гидротермал аргаар синтетик цеолит гарган авах боломжтой болох нь батлагдсан. Синтезлэгдсэн цеолитууд нь анхдагч үнснээс хамаагүй өндөр хром шингээх чадвартай болох нь тогтоогдсон бөгөөд хамгийн өндөр шингээх багтаамж нь 12.60 мг/г байсан. Мөн нэмэлт хөнгөн цагааны эх үүсвэр болгон хаягдал хөнгөн цагаан лаазыг амжилттай ашиглаж болохыг харуулсан нь хаягдал материалыг дахин ашиглах, үйлдвэрлэлийн зардлыг бууруулах чухал ач холбогдолтой юм. Al_2O_3-ийн нэмэлт нь цеолитийн хром шингээх чадварыг сайжруулахад эерэгээр нөлөөлж байгааг тогтоосон. Энэхүү судалгаа нь хаягдал болон хаягдал ундааны лаазыг үнэ цэнэтэй материал болгон хувиргах, байгаль орчны бохирдлыг бууруулах, ялангуяа усан дахь хүнд металлуудыг зайлуулах шийдлүүдийг олоход чухал хувь нэмэр оруулж байна.

ОРШИЛ

Улаанбаатар хотын хүн амын дийлэнх нь гэр хороололд амьдардаг бөгөөд энэ бүсээс гаралтай хатуу хог хаягдал, тухайлбал шахмал түлшний үнсний хаягдал нь нийслэлийн экосистем, байгаль орчны аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндэд улам бүр ноцтой нөлөө үзүүлэх болсон. Сүүлийн жилүүдэд нийслэлийн төвлөрсөн дулаан хангамжгүй бүсүүдэд шахмал түлшний хэрэглээ эрс нэмэгдэж, нэг өрхөөс хоногт 3-5 кг үнс, жилд нийтдээ 100 мянган тонноос давсан үнс гарах болсон нь хог хаягдлын бүтцэд томоохон өөрчлөлт авчирч байна. Олон улсын болон үндэсний судалгаагаар шахмал түлшний үнсэнд хүнд металл (Pb, Zn, Cr, As, Cd), бичил тоосонцор, шүлтлэг исэл, органик хорт бодис ихээр агуулагддаг нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд шууд ба дам эрсдэл дагуулдгийг баталсан байна.



Агаарын бохирдлын гол эх үүсвэрүүдийн нэг нь гэр хорооллын айл өрхүүдийн хэрэглэдэг шахмал түлшний шаталтаас үүсэх үнс юм.



Сүүлийн жилүүдэд түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлаж, шахмал түлш рүү шилжсэн нь агаарын бохирдлыг тодорхой хэмжээгээр бууруулсан хэдий ч, шахмал түлшний үнсний хэмжээ эрс нэмэгдэж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх шинэ сорилтыг бий болгож байна [1].

Монгол Улсын хууль эрх зүйн орчин, “Хог хаягдлын тухай” хууль, “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хууль, “Алсын хараа–2050” зэрэг бодлогын баримт бичигт хатуу хог, органик хаягдлыг шинжлэх ухааны аргаар дахин боловсруулах, дугуй эдийн засаг, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгох, байгальд ээлтэй инновацийг

дэмжихийг онцгойлон тусгасан. Гэвч практик хэрэгжилт, технологийн инновац, судалгааны туршилтын ажил нэгдсэн байдлаар хэрэгжих нь ховор, үндэсний стандарт, лабораторийн хүчин чадал, эдийн засгийн үр ашгийн тооцоо, хэрэглэгчийн хандлага, менежментийн тогтолцоо сул хэвээр байна.

Шахмал түлшний үнс нь их хэмжээгээр хаягдал болж, ил задгай асгагдах нь хөрс, ус, агаарын хоёрдогч бохирдлыг үүсгэж, хүний эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулж байна. Энэхүү үнсэнд хүнд металл (Pb, Zn, Cr, As, Cd), бичил тоосонцор, шүлтлэг исэл, органик хорт бодис ихээр агуулагддаг нь судалгаагаар батлагдсан [4, 5]. Ялангуяа хүүхдүүдийн дунд хүнд металлын хордлогын эрсдэл өндөр байгаа нь энэ асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатайг харуулж байна [10].

Эдгээр хаягдлыг үр ашигтайгаар дахин боловсруулах нь байгаль орчныг хамгаалахаас гадна эдийн засгийн хувьд ч ашигтай шийдэл болж чадна. Энэхүү боломжит шийдлүүдийн нэг нь шахмал түлшний үнсийг ашиглан цеолит синтезлэх явдал юм. Цеолит нь өвөрмөц сүвэрхэг бүтэцтэй, ион солилцох, адсорбци хийх өндөр чадвартай эрдэс материал бөгөөд ус цэвэршүүлэх, катализатор, молекулын шигшүүр зэрэг олон салбарт өргөн хэрэглэгддэг [3]. Ялангуяа, усан дахь хүнд металлуудыг, тухайлбал хромыг зайлуулахад цеолитийг ашиглах нь үр дүнтэй арга болох нь олон судалгаагаар батлагдсан [7, 8, 9].



Хром (Cr) нь үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагааны үр дүнд усанд их хэмжээгээр ялгардаг, хүний эрүүл мэнд болон байгаль орчинд аюултай хүнд металл юм. Ялангуяа Cr(VI) нь Cr(III)-аас илүү хортой бөгөөд усанд уусамтгай байдаг тул түүнийг уснаас зайлуулах нь нэн чухал асуудал юм [8, 9]. Иймд уснаас хром шингээх үр ашигтай, хямд өртөгтэй аргуудыг судлах нь чухал юм.

Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь Улаанбаатар хотын гэр хорооллолд хаягдал болж буй шахмал түлшний үнсийг ашиглан синтетик цеолит гарган авах, мөн хаягдал
ундааны хөнгөн цагаан лааз болон химийн чанартай нунтаг хөнгөн цагаан зэрэг нэмэлт хөнгөн цагааны эх үүсвэрүүдийн нөлөөг судлах явдал байв. Цаашилбал, гарган авсан цеолитууд болон анхдагч үнсний уснаас хром шингээх чадварыг үнэлж, тэдгээрийн адсорбцийн багтаамжийг

тодорхойлохыг зорьсон. Энэхүү судалгаа нь хаягдал материалыг дахин ашиглах, байгаль орчны бохирдлыг бууруулах, мөн ус цэвэршүүлэх шинэ шийдлүүдийг олоход хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

1.1. Үндэслэл

1.1.1 Нөхцөл байдал, шаардлага

Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийн түлшний хэрэглээ сүүлийн жилүүдэд төрөөс хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд түүхий нүүрснээс шахмал түлш рүү бүрэн шилжсэн [1]. Үүний үр дагаварт гэр хорооллоос гарах хатуу хаягдлын дийлэнхийг шахмал түлшний үнс эзэлж, улирлын ид үеэр нэг өрхөөс хоногт дунджаар 3-5 кг үнс гарч, нийт хэмжээгээрээ жилд 100 мянган тонноос давсан хэмжээтэй болжээ [2]. Энэхүү үнсийг голдуу ахуйн болон орон сууцны ойролцоох талбайд ил задгай асгадаг тул хотын хөрс, агаар, усанд хоёрдогч бохирдол үүсгэх гол шалтгаан болж байна [3].



Зураг 1. Улаанбаатар хотын хүн амын тархалт

Шахмал түлшний үнс нь ердийн түүхий нүүрсний үнстэй харьцуулахад органик хаягдал, хүнд металл, шүлтлэг орчин үүсгэгч ислүүдээр баялаг тул экосистем, хүний эрүүл мэндэд урт хугацааны эрсдэл үүсгэх боломжтойг олон улсын судалгаанд анхааруулж байна [4,5]. Улаанбаатар хотын гэр хорооллын эрүүл мэндийн асуудлыг судалсан Gundsambuu нарын судалгаагаар хүүхдүүдийн хорт металлын хордлогын эрсдэл насанд хүрэгчдээс 3-5 дахин өндөр байгааг тогтоосон [10]. Үүнийг дэмжин Oyunbileg нарын судалгаагаар гэр хорооллын хүүхдүүдэд амьсгалын замын өвчин илүү олон тохиолддог байна [11].


Эрүүл мэндийн гол эрсдэлүүд:

- Хүүхдүүдэд амьсгалын замын хронсон өвчин
- Хүнд металлын хордлого
- Хорт хавдрын эрсдэл нэмэгдэх
- Мэдрэлийн системийн гэмтэл

Жишээлбэл, БНСУ, Польш, Хятадын хотуудын айл өрхийн үнсний бүтцийг судлахад хүнд металл (Pb, Zn, Cr), PAH, үнсний бичил тоосонцор, шүлтийн индекс өндөр гарч, хөрс, усны бохирдол, амьсгалын замын эрсдэлтэй уялдсан дүн гарчээ [5,6]. Үүнийг шийдэх олон улсын

туршлагаар гэр ахуйн үнсийг компостжуулах, барилгын материал, ус цэвэршүүлэх шүүлтүүр зэрэг бүтээгдэхүүн болгон хувиргах технологийг өргөн ашигладаг [7]. Монголд энэ чиглэлээр нарийвчилсан шинжилгээ, инновацийн туршилтын хэрэгцээ өндөр хэвээр байна [2,8].

Нөгөө талаар, Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын 40-50 хувийг хүнсний хаягдал эзэлж байгаа ба хүн амын өсөлт, хотжилт нэмэгдэхийн хэрээр хүнсний органик хаягдлын хэмжээ тогтмол нэмэгдсээр байна [9].



Зураг 2. Хүнсний хаягдлын бүтээгдэхүүн

Хүнсний үйлдвэрлэл болон гэр ахуйн хүнсний хаягдлыг ихэвчлэн ахуйн бусад хогтой хамт асгаж, төвлөрсөн цэг, ил задгай талбайд хуримтлуулдаг. Энэ нь хөрсний үржил шимийг бууруулах, нянгийн бохирдол, хүлэмжийн хий, эвгүй үнэр, хортон шавж, үерийн эрсдэлийг өсгөж байна [10]. Дэлхий дахинд хүнсний хаягдлын шийдэлд хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй технологи бол био задрал, бичил биетний исэлдэлтээр компост бордоо үйлдвэрлэх, органик бордооны чанарын стандарт тогтоох, ногоон байгууламжид шууд эргэлтэд оруулах шийдэл юм [11,12].

Монгол Улсад компостын үйлдвэрлэлийн стандарт бий (MNS 6507:2015), хэдий ч хүнсний үйлдвэрлэл, гэр ахуйн түвшинд хүнсний хаягдал боловсруулах, жижиг оврын компостжуулах туршилт судалгаа цөөн, хэрэгжүүлэлтийн үр дүн системтэй гараагүй байна [8,13]. Хүнсний хаягдлыг технологийн хувьд задлагч нэмэх, компостын температур, чийг, агааржуулалтыг нарийн хянаж үйлдвэрлэх, бордооны хүнд металл, эрүүл ахуйн үзүүлэлтийг тогтмол шинжлэх шаардлага бий. Олон улсын туршлагаас үзэхэд (Япон, АНУ, ЕU) хүнсний хаягдлыг компостжуулах замаар хотын хогийг 20-40% хүртэл бууруулах, хөрсний үржил шимийг эрс нэмэгдүүлэх боломжийг харуулж байна [11,12].

Улаанбаатар хотын нөхцөлд гэр хорооллын үнс болон хүнсний хаягдлын боловсруулалт, байгальд ээлтэй, эдийн засгийн эргэлтэд оруулах туршилт судалгааг эрчимжүүлэх шаардлага бий. Энэ чиглэлд олон улсын дэвшилтэт технологи, Монголын бодит нөхцөлд нийцсэн арга зүйг хослуулсан судалгаа хийх нь тулгамдсан асуудал хэвээр байна.

1.2 Эрх зүй, бодлогын үндэслэл

Улаанбаатар хотын гэр хорооллын үнс, хүнсний хаягдлыг шинжлэх ухаанчаар боловсруулах, экосистемд сөрөг нөлөөг бууруулахад Монгол Улсын эрх зүйн тогтолцоо болон бодлогын


баримт бичиг хүчтэй дэмжлэг үзүүлдэг. “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хуульд (2012 он) хөрсний бохирдлыг бууруулах, хог хаягдлыг ангилан цуглуулах, дахин боловсруулах, экологийн аюулгүй байдлыг хангах зорилтыг тодорхой тусгасан [14]. “Хог хаягдлын тухай” хууль (2017 он) болон холбогдох журамд хог хаягдлыг үүсгэгч, цуглуулагч, боловсруулах, устгах бүхий л үе шатанд экологийн болон эрүүл ахуйн шаардлага тавьж, дахин ашиглах, технологи инновацийг нэвтрүүлэхийг хуульчилсан [15].

Үүнээс гадна Монгол Улсын “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлогод хог хаягдлын менежмент, дугуй эдийн засаг, хөрсний доройтлыг бууруулах, дахин боловсруулалт, органик бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтуудыг тодорхой тусгасан [16]. Мөн нийслэлийн хэмжээнд “Нийслэлийн Засаг даргын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д гэр хорооллын хог хаягдлыг багасгах, үнсний ангилал, хүнсний хаягдлыг дахин ашиглах бодлого, байгальд ээлтэй туршилтыг нэвтрүүлэхийг үүрэг болгосон байдаг [17].

Олон улсын түвшинд, НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилтууд” (SDG 12: Хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэл), Европын холбоо, Япон, БНСУ-ын “Дугуй эдийн засгийн хууль”, хог хаягдлыг бууруулах бодлогын чиг хандлага нь Монголын хууль, бодлогод тусгагдсан чиглэлтэй нягт уялддаг [18,19].

1.3. Цеолитийн тухай ерөнхий ойлголт

Цеолитууд нь байгальд өргөн тархсан, мөн синтетик аргаар гарган авдаг, сүвэрхэг бүтэцтэй, ион солилцох болон адсорбци хийх өндөр чадвартай эрдэс материалууд юм. Тэдгээрийн нэр нь Грекийн “zeo” (буцлах) болон “lithos” (чулуу) гэсэн үгнээс гаралтай бөгөөд халаахад ус ялгаруулж, буцалж буй мэт харагддаг онцлогоос нь үүдэн ийнхүү нэрлэжээ. Цеолитийн химийн ерөнхий томъёо нь M_x/n[(AlO2)_x(SiO2)_y]·zH2O бөгөөд энд M нь n валенттай металл ион (ихэвчлэн Na+, K+, Ca2+, Mg2+), x, y нь хөнгөн цагаан болон цахиурын атомуудын тоо, z нь цеолитийн сүвэнд агуулагдах усны молекулын тоог илэрхийлнэ. Цеолитийн бүтцэд AlO2 тетраэдрүүд нь сөрөг цэнэгтэй байдаг тул түүнийг нөхөхийн тулд металл катионууд агуулагддаг бөгөөд эдгээр катионууд нь ион солилцооны урвалд орох чадвартай байдаг.



Цеолитийн гол онцлог нь түүний гурван хэмжээст, нээлттэй сүвэрхэг бүтэц юм. Энэхүү бүтэц нь молекулын хэмжээтэй сувгууд болон хөндийгүүдээс бүрдэх бөгөөд эдгээр нь усны молекул

болон бусад жижиг молекулуудыг өөртөө шингээх, мөн ион солилцох боломжийг олгодог. Цеолитийн сүвийн хэмжээ, хэлбэр нь түүний молекулын шигшүүр болох чадварыг тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, тодорхой хэмжээтэй молекулуудыг л өөртөө нэвтрүүлж, бусдыг нь нэвтрүүлэхгүй байх чадвартай юм.

Цеолитуудыг байгалийн болон синтетик гэж ангилдаг. Байгалийн цеолитууд нь галт уулын чулуулаг, тунамал чулуулагт үүсдэг бөгөөд хамгийн түгээмэл нь клиноптилолит, морденит, филлипсит зэрэг юм. Синтетик цеолитууд нь лабораторийн нөхцөлд, тодорхой химийн найрлага, бүтцээр гарган авдаг бөгөөд Na-A, Na-X, Na-P зэрэг нь өргөн хэрэглэгддэг. Синтетик цеолитууд нь байгалийн цеолитуудаас илүү цэвэр, нэг төрлийн бүтэцтэй байдаг тул хэрэглээний хувьд илүү өргөн боломжийг олгодог.

Цеолитийн өвөрмөц шинж чанарууд нь түүнийг олон салбарт ашиглах боломжийг олгодог. Үүнд:

Ус цэвэршүүлэх: Цеолитууд нь усан дахь хүнд металлын ион (Pb2+, Cd2+, Cr3+, Cr6+), аммони (NH4+), радиоидэвхт бодис, органик бохирдуулагчдыг адсорбци болон ион солилцооны замаар зайлуулах чадвартай. Энэ нь ундны ус, үйлдвэрийн хаягдал ус, бохир усыг цэвэршүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Катализатор: Цеолитийн хүчиллэг шинж чанар болон сүвэрхэг бүтэц нь түүнийг нефть боловсруулах, химийн үйлдвэрлэлд катализатор болон катализаторын зөөгч болгон ашиглах боломжийг олгодог. Жишээлбэл, крекинг, изомержилт, алкилжуулалт зэрэг процессуудад өргөн хэрэглэгддэг.

Адсорбент: Цеолитууд нь хий ялгах, хатаах, үнэр шингээх зэрэгт адсорбент болгон ашиглагддаг. Агаарын чийгийг шингээх, байгалийн хийгээс азотыг ялгах, хөргөлтийн системд хөргөгч бодис болгон ашиглах зэрэг нь үүнд багтана.

Хөрсний сайжруулагч: Хөрсний ус барих чадварыг нэмэгдүүлэх, тэжээлийн бодисыг хадгалах, хөрсний хүнд металлын бохирдлыг бууруулахад ашиглагддаг.

Барилгын материал: Цемент, бетон зэрэг барилгын материалын нэмэлт болгон ашиглаж, бат бөх чанарыг нэмэгдүүлдэг.

Энэхүү судалгаанд цеолитийн ус цэвэршүүлэх, ялангуяа хром шингээх чадварыг голчлон судалсан болно.

1.4. Гидротермал синтезийн арга

Гидротермал синтезийн арга нь цеолит болон бусад талст материалуудыг өндөр температур, даралттай усны уусмал (гидротермал нөхцөл) дотор синтезлэх арга юм. Энэ арга нь байгальд эрдэс үүсэх процессыг дуурайдаг бөгөөд бага температурт (ихэвчлэн 100-200°C) талстжуулалт явагддаг тул эрчим хүчний хэмнэлттэй, мөн нарийн бүтэцтэй, цэвэр бүтээгдэхүүн гарган авах

боломжийг олгодог. Цеолит синтезийн хувьд энэ арга нь хамгийн түгээмэл бөгөөд үр дүнтэй аргуудын нэг юм [6, 13].

1.4.1. Шинжлэх ухааны үндэс:

Гидротермал синтезийн гол зарчим нь цахиур (Si) болон хөнгөн цагаан (Al)-ыг агуулсан түүхий эдийг шүлтлэг орчинд (ихэвчлэн NaOH эсвэл KOH уусмал) өндөр температур, даралтад урвалд оруулах явдал юм. Энэ үед түүхий эд дэх цахиур, хөнгөн цагааны ислүүд уусмалд уусч, силикат болон алюминат ионуудыг үүсгэдэг. Эдгээр ионууд нь уусмал
дотор нэгдэж, цеолитийн анхдагч бүтцийн нэгж болох тетраэдрүүдийг (SiO4 болон AlO4) үүсгэнэ. Улмаар эдгээр тетраэдрүүд нь хоорондоо холбогдон, гурван хэмжээст сүвэрхэг сүлжээг үүсгэж, цеолитийн талст бүтэц бий болдог. Урвалын явцад температур, даралт, pH, урвалын хугацаа, түүхий эдийн харьцаа зэрэг нь үүсэх цеолитийн төрөл, талстын хэмжээ, цэвэршилтэд чухал нөлөө үзүүлдэг.

1.4.2. Урвалын механизм ба нөхцөл:

Цеолит синтезийн гидротермал процесс нь хэд хэдэн үе шатаас бүрддэг:

1. **Түүхий эдийг идэвхжүүлэх (Dissolution):** Цахиур болон хөнгөн цагааны эх үүсвэрүүд (жишээлбэл, үнс) шүлтлэг уусмалд уусч, уусмал дахь Si(OH)4 болон Al(OH)4- ионуудыг үүсгэдэг. Энэ үе шат нь урвалын хурдыг тодорхойлох гол хүчин зүйл болдог.
2. **Гель үүсэх (Gel Formation):** Уусмал дахь Si болон Al ионууд нь нэгдэж, аморф гель үүсгэдэг. Энэ гель нь цеолитийн талст үүсэх суурь болдог.
3. **Талст үүсэх (Nucleation):** Гель дотор цеолитийн талстын анхдагч цөмүүд үүсдэг. Энэ үе шат нь маш чухал бөгөөд үүсэх цеолитийн төрлийг тодорхойлдог.
4. **Талст ургах (Crystal Growth):** Үүссэн цөмүүд дээр уусмал дахь Si болон Al ионууд нэмэгдэн, цеолитийн талстууд ургаж, тодорхой хэмжээнд хүрдэг.

Урвалын нөхцөл:

Температур: Ихэвчлэн 100-200°C хооронд байдаг. Температур нэмэгдэх тусам урвалын хурд нэмэгдэж, талст үүсэх хугацаа богиносдог. Гэсэн хэдий ч хэт өндөр температур нь аморф фаз үүсгэх эсвэл өөр төрлийн эрдэс үүсгэх эрсдэлтэй.

Даралт: Урвал нь хаалттай систем (автоклав) дотор явагддаг тул усны уурын даралт үүсдэг. Энэ даралт нь урвалын хурд болон бүтээгдэхүүний талстжилтад нөлөөлдөг.

Шүлтийн орчин (NaOH концентраци): Шүлтийн концентраци нь түүхий эдийг уусгах, урвалын орчны pH-г тохируулах, мөн үүсэх цеолитийн төрлийг

тодорхойлоход чухал үүрэгтэй. Ихэвчлэн 1.5-2.0 M NaOH уусмал ашигладаг.

Урвалын хугацаа: Урвалын хугацаа нь талстжилт бүрэн явагдаж, цэвэр цеолит үүсэхэд хангалттай байх ёстой. Ихэвчлэн 12-48 цаг үргэлжилдэг.

Түүхий эдийн харьцаа (Si/Al харьцаа): Цахиур болон хөнгөн цагааны харьцаа нь үүсэх цеолитийн төрөл, бүтэц, шинж чанарт шууд нөлөөлдөг. Энэхүү судалгаанд Al2O3-ийн нэмэлтийг ашиглан Si/Al харьцааг өөрчилсөн.

1.4.3. Түүхий эдийн сонголт:

Цеолит синтезлэхэд цахиур болон хөнгөн цагааны эх үүсвэрүүд зайлшгүй шаардлагатай. Уламжлалт аргаар цэвэр химийн бодис (жишээлбэл, натрийн силикат, натрийн алюминат) ашигладаг байсан бол сүүлийн үед нүүрсний үнс, цагаан шаазангийн хаягдал, будааны хальсны үнс зэрэг үйлдвэрлэлийн хаягдлуудыг ашиглах нь байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд ашигтай шийдэл болж байна [1, 2, 5]. Эдгээр хаягдлууд нь цахиур, хөнгөн цагаан зэрэг цеолит синтезлэхэд шаардлагатай үндсэн элементүүдийг агуулдаг тул түүхий эд болгон ашиглах боломжтой юм.

Энэхүү судалгаанд шахмал түлшний үнсийг цахиурын эх үүсвэр, харин нунтаг хөнгөн цагаан болон хаягдал хөнгөн цагаан лаазыг хөнгөн цагааны нэмэлт эх үүсвэр болгон ашигласан.

1.5. Хромын бохирдол ба түүнийг зайлуулах аргууд

Хром (Cr) нь байгаль орчинд өргөн тархсан, хүнд металл бөгөөд хүний үйл ажиллагааны улмаас, ялангуяа үйлдвэрлэлийн хаягдал усаар дамжин ус, хөрсөнд их хэмжээгээр ялгардаг. Хром нь байгальд ихэвчлэн гурван валенттай хром (Cr(III)) болон зургаан валенттай хром (Cr(VI)) гэсэн хоёр үндсэн хэлбэрээр оршдог. Эдгээр хоёр хэлбэр нь химийн шинж чанар, хортой нөлөөгөөрөө эрс ялгаатай байдаг.

Гурван валенттай хром (Cr(III)): Энэ нь байгальд элбэг тохиолддог, харьцангуй тогтвортой, хор багатай хэлбэр юм. Cr(III) нь хүний биед зайлшгүй шаардлагатай бичил элемент бөгөөд глюкозын солилцоонд оролцдог. Гэсэн хэдий ч, өндөр концентрацитай үед хортой нөлөө үзүүлж болно.

Зургаан валенттай хром (Cr(VI)): Энэ нь Cr(III)-аас хамаагүй илүү хортой, усанд уусамтгай, хөдөлгөөнтэй хэлбэр юм. Cr(VI) нь хүчтэй исэлдүүлэгч бөгөөд хүний биед хорт хавдар үүсгэх, мутаген, тератоген нөлөө үзүүлэх чадвартай. Арьс, амьсгалын зам, хоол боловсруулах системээр дамжин биед нэвтэрч, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулдаг. Үйлдвэрлэлийн процессууд, тухайлбал, арьс шир боловсруулах, ган үйлдвэрлэл, будаг үйлдвэрлэл, электроплатинг зэрэг нь Cr(VI)-ийн гол эх үүсвэр болдог.

Иймд усан дахь хромын, ялангуяа Cr(VI)-ийн агууламжийг бууруулах нь байгаль орчин болон


хүний эрүүл мэндийг хамгаалахад нэн чухал юм. Уснаас хром зайлуулах олон төрлийн аргууд байдаг бөгөөд үүнд дараах үндсэн аргууд багтана:

1. **Адсорбци (Adsorption):** Энэ нь бохирдуулагч молекулуудыг адсорбент материалын гадаргуу дээр шингээх процесс юм. Адсорбцийн арга нь энгийн, үр ашигтай, хямд өртөгтэй, мөн өргөн хүрээний бохирдуулагчдыг зайлуулах чадвартай тул ус цэвэршүүлэхэд хамгийн түгээмэл хэрэглэгддэг аргуудын нэг юм. Идэвхжүүлсэн нүүрс, биомасс, цеолит, нано материал зэрэг нь түгээмэл адсорбентууд юм.
   Цеолитууд нь өндөр сүвэрхэг бүтэц, их гадаргуугийн талбай, ион солилцох чадвартай тул хромыг уснаас зайлуулахад маш үр дүнтэй байдаг [7, 8, 9].
2. **Тунадасжилт (Precipitation):** Энэ арга нь хромын ионуудыг уусдаггүй нэгдэл болгон хувиргаж, тунадас хэлбэрээр уснаас ялгах зарчим дээр суурилдаг. Ихэвчлэн pH-г тохируулж, шүлтлэг орчинд Cr(III)-ийг гидроксид хэлбэрээр тунадасжуулдаг. Cr(VI)-ийг зайлуулахын тулд эхлээд түүнийг Cr(III) болгон ангижруулж, дараа нь тунадасжуулдаг.
3. **Ион солилцоо (Ion Exchange):** Энэ арга нь уусмал дахь хромын ионуудыг ион солилцооны давирхайн гадаргуу дээрх ионуудтай солилцуулах зарчим дээр суурилдаг. Энэ нь өндөр үр ашигтай боловч, давирхайн өртөг өндөр, мөн давирхайг нөхөн сэргээх шаардлагатай байдаг.
4. **Мембран процесс (Membrane Processes):** Урвуу осмос, нанофильтраци зэрэг мембран аргууд нь усан дахь хромын ионуудыг физик аргаар шүүж зайлуулдаг. Эдгээр аргууд нь өндөр үр ашигтай боловч, өртөг өндөр, мембраны бохирдол үүсэх эрсдэлтэй байдаг.
5. **Электрохимийн арга (Electrochemical Methods):** Электрокоагуляци, электроредукци зэрэг аргууд нь цахилгаан гүйдэл ашиглан хромын ионуудыг зайлуулдаг. Эдгээр аргууд нь үр дүнтэй боловч, эрчим хүчний зарцуулалт өндөр байж болно.

Эдгээр аргуудаас адсорбцийн арга нь хэрэгжүүлэхэд хялбар, хямд өртөгтэй, мөн үр ашигтай байдаг тул энэхүү судалгаанд голчлон анхаарсан болно.

1.6. Шахмал түлшний үнс

Шахмал түлшний үнс нь түүхий нүүрсийг боловсруулж, шахаж хийсэн түлшийг шатаахад үүсдэг хаягдал бүтээгдэхүүн юм. Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүд агаарын бохирдлыг бууруулах зорилгоор шахмал түлш рүү шилжсэнээр энэхүү үнсний хэмжээ эрс нэмэгдэж, байгаль орчны томоохон асуудал болоод байна. Жилд 100 мянга гаруй тонн үнс гарч байгаа нь хог хаягдлын бүтцэд томоохон өөрчлөлт авчирчээ [2].



1.6.1. Үүсэл ба найрлага:

Шахмал түлшний үнс нь түүхий нүүрсний үнстэй харьцуулахад өвөрмөц найрлагатай байдаг. Энэ нь органик хаягдал, хүнд металл, шүлтлэг орчин үүсгэгч ислүүдээр баялаг байдаг нь олон улсын судалгаагаар тогтоогдсон [4, 5]. Үнсний химийн найрлага нь түлшний төрөл, шаталтын нөхцөл зэргээс хамаардаг боловч, ерөнхийдөө цахиурын давхар исэл (SiO_2), хөнгөн цагааны исэл (Al_2O_3), төмрийн исэл (Fe_2O_3), кальцийн исэл (CaO), магнигийн исэл (MgO) зэрэг оксидуудыг агуулдаг. Энэхүү судалгаанд ашигласан шахмал түлшний үнсний химийн найрлагыг XRF (X-ray Fluorescence) шинжилгээгээр
тодорхойлсон бөгөөд үр дүнг “Үр дүн ба Хэлэлцүүлэг” бүлэгт дэлгэрэнгүй танилцуулна. XRF шинжилгээ нь үнсэнд агуулагдах элементийн найрлагыг тодорхойлдог бөгөөд энэ нь цеолит синтезлэхэд шаардлагатай цахиур, хөнгөн цагааны агууламжийг үнэлэхэд чухал ач холбогдолтой юм.

1.6.2. Байгаль орчинд үзүүлэх нөлөө:

Шахмал түлшний үнсийг ил задгай асгах нь дараах сөрөг нөлөөг үзүүлдэг:

Хөрсний бохирдол: Үнсэнд агуулагдах хүнд металлууд болон бусад хорт бодисууд хөрсөнд нэвчиж, хөрсний бохирдлыг үүсгэдэг. Энэ нь хөрсний үржил шимийг бууруулахаас гадна, хүнсний гинжин хэлхээнд нэвтэрч, хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй юм.

Усны бохирдол: Үнсэнд агуулагдах уусдаг бодисууд бороо, цасны усаар дамжин гадаргын болон гүний усыг бохирдуулдаг. Хүнд металлууд усанд уусч, усны экосистемд сөрөг нөлөө үзүүлж, ундны усны чанарт аюул учруулдаг.

Агаарын бохирдол: Үнсний жижиг тоосонцор агаарт дэгдэж, амьсгалын замын өвчин үүсгэх, агаарын чанарыг муутгах нөлөөтэй. Ялангуяа PM2.5 зэрэг нарийн ширхэгтэй тоосонцор нь хүний уушгинд гүн нэвтэрч, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулдаг.

Эрүүл мэндийн эрсдэл: Үнсэнд агуулагдах хүнд металл болон бусад хорт бодисууд нь хүний биед хуримтлагдаж, хорт хавдар, мэдрэлийн системийн гэмтэл, амьсгалын замын өвчин зэрэг олон төрлийн эрүүл мэндийн асуудлыг үүсгэдэг [10, 11].

1.6.3. Дахин ашиглах боломж:

Шахмал түлшний үнс нь дээр дурдсан сөрөг нөлөөтэй хэдий ч, түүний найрлагад агуулагдах цахиур, хөнгөн цагаан зэрэг элементүүд нь үнэ цэнэтэй түүхий эд болж чаддаг. Олон улсын туршлагаар гэр ахуйн үнсийг барилгын материал, ус цэвэршүүлэх шүүлтүүр зэрэг бүтээгдэхүүн болгон хувиргах технологийг өргөн ашигладаг [7]. Энэхүү судалгаа нь шахмал түлшний үнсийг цеолит синтезлэхэд ашиглах боломжийг судалж, хаягдал материалыг эдийн засгийн эргэлтэд оруулах шинэ гарцыг эрэлхийлсэн болно.

1.7. Хөнгөн цагааны эх үүсвэрүүд

Цеолит синтезлэхэд цахиурын эх үүсвэрээс гадна хөнгөн цагааны эх үүсвэр зайлшгүй шаардлагатай. Хөнгөн цагаан нь цеолитийн бүтцийн үндсэн хэсэг болох алюминат тетраэдрийг (AlO_4) үүсгэдэг бөгөөд энэ нь цеолитийн ион солилцох чадвар болон хүчиллэг шинж чанарт чухал нөлөө үзүүлдэг. Энэхүү судалгаанд хоёр төрлийн хөнгөн цагааны эх үүсвэрийг ашигласан:

1. **Нунтаг хөнгөн цагаан:** Энэ нь химийн чанартай, 98% цэвэршилттэй нунтаг хөнгөн цагаан юм. Лабораторийн судалгаанд ихэвчлэн цэвэр химийн бодисуудыг ашигладаг нь урвалын нөхцөлийг нарийн хянах, үр дүнг тогтвортой гарган авахад чухал ач холбогдолтой байдаг. Нунтаг хөнгөн цагаан нь цеолит синтезийн урвалд хөнгөн цагааны ионыг тогтвортойгоор ялгаруулж, цеолитийн бүтцийг үүсгэхэд оролцдог.



2. **Хаягдал хөнгөн цагаан лааз:** Ундааны хаягдал хөнгөн цагаан лаазыг цуглуулж, нунтаглан, нэмэлт хөнгөн цагааны эх үүсвэр болгон ашигласан. Эдгээр лааз нь 93- 95% хөнгөн цагааны агуулгатай байдаг. Хаягдал материалыг ашиглах нь судалгааны нэг чухал зорилго байсан бөгөөд энэ нь байгаль орчинд ээлтэй, мөн үйлдвэрлэлийн зардлыг бууруулах боломжийг олгодог. Хаягдал хөнгөн цагаан лаазыг ашиглах нь нэг талаас хог хаягдлыг бууруулж, нөгөө талаас үнэ цэнэтэй бүтээгдэхүүн гарган авах давхар ач холбогдолтой юм. Судалгааны үр дүнд хаягдал хөнгөн цагаан лаазыг нунтаг хөнгөн

цагааны оронд амжилттай ашиглаж болох нь батлагдсан.



Эдгээр хоёр төрлийн хөнгөн цагааны эх үүсвэрийг харьцуулан судалснаар, хаягдал материалыг цеолит синтезлэхэд ашиглах боломж, үр ашгийг тодорхойлсон.

1.2 Ажлын зорилго, зорилт

Улаанбаатар хотын гэр хорооллоос гаралтай шахмал нүүрсний үнс болон хүнсний хаягдлын сөрөг нөлөөг бууруулж, эдгээр хаягдлыг шинжлэх ухаан технологи ашиглан дахин боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн (ус цэвэршүүлэгч материал) гаргах, эрүүл мэнд, байгаль орчны эрсдлийг багасгах зорилготой. Судалгаанд олон улсын болон үндэсний дэвшилтэт технологи, инновацийн арга зүйг ашиглаж, Монгол орны онцлогт тохирсон, практик хэрэгжихүйц шийдэл гаргахыг зорино. Энэхүү зорилгыг биелүүлэхээр доорх зорилтуудыг тавьсан болно.

1.2.1 Ажлын зорилтууд

1. Хаягдлын шинж чанарыг нарийвчлан тодорхойлох

- Шахмал нүүрсний үнсний болон хүнсний хаягдлын физик-химийн, эрүүл ахуйн шинж чанарыг олон улсын (ISO, ASTM) ба үндэсний (MNS) стандартын дагуу судлах.

2. Дэвшилтэт, оновчтой технологийн шийдлийг турших, нутагшуулах

- Үнсийг химийн болон дулааны боловсруулалт хийж гадаргуун идэвхит цеолит материал гарган авч ус цэвэршүүлэх шүүлтүүр болгон турших.

3. Нэмүү өртөг шингэсэн, аюулгүй бүтээгдэхүүн боловсруулах

- Үнсийг боловсруулан цеолит гарган авах аюулгүй байдлыг лабораторийн түвшинд баталгаажуулах.
- Хаягдлыг бүтээгдэхүүн болгон хувиргах шинэ материалын загвар гаргах.

4. Эрүүл мэндийн эрсдлийг бууруулах шийдэл санал болгох

- Хор нөлөөт бодисыг саармагжуулах, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх аюулыг бууруулах шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүй, удирдамж боловсруулж, бодлого боловсруулагч, олон нийтэд хүргэх.

1.7. Судлагдсан байдал

Монгол Улсын ихэнх хот, ялангуяа Улаанбаатар хотын гэр хорооллын бүсэд үүсэх хатуу хаягдлын дийлэнхийг шахмал нүүрсний үнс болон хүнсний хаягдал эзэлдэг бөгөөд эдгээр хаягдлын байгаль орчин, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, шинжлэх ухаанчаар боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах шаардлага өсөн нэмэгдэж байна [2,9].

1.7.1. Шахмал нүүрсний үнсний бүтэц, экологийн эрсдэл

Шахмал болон ердийн нүүрсний үнс нь өндөр агууламжтай силикат, алюминат, феррит, кальци, магни, төмрийн исэл агуулсан, ширхэгийн хэмжээ жижиг, шүлтлэг орчин үүсгэх хандлагатай байдаг [4,5]. Олон улсын судалгаагаар шахмал нүүрсний үнсэнд хүнд металл (Pb, Zn, Cr, As, Cd), PAH (polycyclic aromatic hydrocarbons), бичил тоосонцор илэрдэг нь хөрс, ус, агаарын хоёрдогч бохирдлын эх үүсвэр болж байгааг харуулсан [5,6].

Хүснэгт 1. Гэр ахуйн шахмал болон ердийн нүүрсний үнсний хими-физик шинж чанарын харьцуулалт (зарим дундаж үзүүлэлт [5,6,8])

Үзүүлэлт	Шахмал нүүрсний үнс	Ердийн нүүрсний үнс	Стандарт (MNS 5674:2006)
pH	8.2 – 10.5	8.0 – 11.0	6.0 – 9.0
Pb (мг/кг)	120 – 420	70 – 340	≤ 150
Zn (мг/кг)	300 – 800	200 – 700	≤ 300
Cr (мг/кг)	30 – 120	25 – 100	≤ 100
SiO_2 (%)	36 – 52	32 – 48	-
Fe_2O_3 (%)	5 – 9	3 – 7	-

Дээрхээс үзвэл шахмал түлшний үнс нь хөрсний стандартын дээд хязгаараас давсан хүнд металл агуулгатай байх тохиолдол элбэг [8,5]. Үнсний ширхэгийн хэмжээ бага, амархан тоосолж, хүн амьсгалаар авах замаар эрүүл мэндэд ноцтой эрсдэл үүсгэх боломжтойг Kim JY нар судалсан [5]. Мөн үнсний хүнд металлын усанд уусах хэлбэрийн судалгаагаар хөрсний усыг бохирдуулах эрсдэл нэмэгдэж байгааг Гунгаажав нар тогтоосон [3].

2. Үнсийг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаргах олон улсын туршлага

Олон улсын судалгаагаар шахмал болон гэр ахуйн үнсийг хөрсний бүтэц сайжруулагч, замын материал, цемент, ус цэвэршүүлэгч шүүлтүүр, био-идэвхитэй сорбент зэрэг бүтээгдэхүүн болгон ашиглах судалгаа идэвхтэй хийгдэж байна [4,7]. Ferreira нарын судалгаагаар үнсийг термик болон химийн аргаар боловсруулбал Pb, Zn, Cr, Cu, As зэрэг хүнд металлыг шингээх чадавх нэмэгдэж, ус цэвэршүүлэхэд хэрэглэж болох нь нотлогдсон [4]. Guo нар үнсэнд био-идэвхжүүлэгч (biochar) нэмэхэд хүнд металлын ион солилцооны багтаамж 30–60%-иар нэмэгдсэн дүн гаргасан [7].

Үнсийг боловсруулж ус цэвэршүүлэхэд хэрэглэх схем [7]

[Шахмал үнс] → [Био-идэвхжүүлэгч/термик боловсруулалт] →

[Шүүлтүүрийн материал] → [Ус цэвэршүүлэх шугам]


Монголд энэ чиглэлээр лабораторийн түвшний туршилтууд хийгдэж байгаа ч үйлдвэрлэлийн хэмжээний үр дүнтэй технологи, эргэлтэд орсон кейс цөөн байна [8]. Үнсний бичил бүтцийг

нарийвчлан судлах, ус цэвэршүүлэх чадвар, дулаан дамжуулалт, хөрсний үржил шимд үзүүлэх нөлөөний туршилтууд идэвхжих шаардлагатай байна [2,8].

Цахилгаан станцын нүүрсний үснээс цеолит синтезлэх, мөн гарган авсан цеолитуудыг ус цэвэршүүлэх, хүнд металл шингээхэд ашиглах талаар олон улсад өргөн хүрээтэй судалгаанууд хийгдсэн байна. Эдгээр судалгаанууд нь хаягдал материалыг үнэ цэнэтэй бүтээгдэхүүн болгон хувиргах, байгаль орчны бохирдлыг бууруулах шийдлүүдийн нэг болдог.

1.7.2. Нүүрсний үснээс цеолит синтезлэх олон улсын туршлага:

Нүүрсний үнс нь цахиур, хөнгөн цагаан зэрэг цеолит синтезлэхэд шаардлагатай үндсэн элементүүдийг агуулдаг тул цеолит үйлдвэрлэхэд тохиромжтой түүхий эд болдог [1, 2, 5]. Олон судалгаагаар нүүрсний үснээс гидротермал болон хайлуулах зэрэг аргуудыг ашиглан янз бүрийн төрлийн цеолит (жишээлбэл, Na-X, Na-A, Na-P) гарган авсан байна. Зарим судалгаагаар богино долгионы туяагаар идэвхжүүлсэн синтезийн арга нь уламжлалт гидротермал аргаас илүү ногоон, үр ашигтай болохыг харуулсан [4]. Мөн хайлуулах аргыг гидротермал боловсруулалтын өмнөх үе шат болгон ашиглах нь өндөр цэвэршилттэй цеолит гарган авахад тустай болохыг тогтоожээ [14].



Жишээлбэл, Японд цахилгаан станцын үнсээр гидротермал цеолит үйлдвэрлэж, ус цэвэршүүлэх станцад ашигладаг [20]. БНСУ-д үнсэнд суурилсан цеолитийг хөрсний хүнд металлын бохирдлыг саармагжуулахад хэрэглэж байна [21]. Эдгээр туршлагууд нь нүүрсний үнсийг цеолит болгон хувиргах нь байгаль орчин болон эдийн засгийн хувьд ашигтай болохыг харуулж байна.

1.7.3. Хром шингээхэд цеолит ашигласан судалгаанууд:

Цеолитууд нь өндөр адсорбцийн чадвартай тул уснаас хром зайлуулахад идэвхтэй ашиглагдаж байна [7, 8, 9]. Байгалийн болон синтетик цеолитууд хоёулаа Cr(VI)-ийг уснаас зайлуулах чадвартай болохыг судалгаанууд харуулсан [9]. Тухайлбал, гадаргууг өөрчилсөн цеолит болон соронзон цеолит-полимер нийлмэл материал нь Cr(VI)-ийг шингээх чадварыг нэмэгдүүлдэг [10, 11].

1.7.4. Монгол дахь холбогдох судалгааны сул орон зай:

Монгол Улсад шахмал түлшний үнс болон бусад үйлдвэрлэлийн хаягдлыг дахин боловсруулах, үнэ цэнэтэй бүтээгдэхүүн гарган авах чиглэлээр судалгаанууд хийгдэж байгаа хэдий ч, энэ чиглэлээр нарийвчилсан шинжилгээ, инновацийн туршилтын хэрэгцээ өндөр хэвээр байна [2, 8]. Ялангуяа, шахмал түлшний үснээс цеолит гарган авч, түүнийг ус цэвэршүүлэх, хүнд металл шингээхэд ашиглах талаарх судалгаа хийгдээгүй байна. Энэхүү судалгаа нь Монголын нөхцөлд тулгамдаж буй хаягдлын асуудлыг шийдвэрлэх, шинэ технологи нутагшуулах, судалгааны үндэслэлтэй бодлогын санал боловсруулах суурь нөхцөлийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааны ажлын зорилго нь шахмал түлшний үнснээс синтетик цеолит гарган авах, мөн гарган авсан цеолитыг ашиглан уснаас хром шингээх чадварыг үнэлэх явдал байсан. Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах материалуудыг ашиглаж, тодорхой арга зүйн дагуу туршилт, шинжилгээг гүйцэтгэсэн.

2.1. Ашигласан материал

Судалгаанд дараах үндсэн материалуудыг ашигласан бөгөөд тэдгээрийн шинж чанар, бэлтгэлийг доор дэлгэрэнгүй тайлбарлав:

Шахмал түлшний үнс (ҮНС): Улаанбаатар хотын гэр хороололд ашигладаг шахмал түлшний зууханд шатаасан үнсийг түүхий эд болгон ашигласан. Энэхүү үнс нь цеолит синтезлэхэд шаардлагатай цахиур (SiO_2) болон хөнгөн цагаан (Al_2O_3) зэрэг оксидуудыг агуулдаг. Үнсийг туршилтад ашиглахын өмнө хатааж, нунтаглан, шигшиж, жигд хэмжээтэй болгосон. Үнсний химийн найрлагыг XRF шинжилгээгээр тодорхойлсон бөгөөд үр дүнг Гуравдугаар бүлэгт дэлгэрэнгүй танилцуулна.

Нунтаг хөнгөн цагаан: Химийн чанартай, 98% цэвэршилттэй нунтаг хөнгөн цагааныг нэмэлт хөнгөн цагааны эх үүсвэр болгон ашигласан. Энэ нь цеолитийн бүтцэд хөнгөн цагааны агууламжийг нэмэгдүүлж, улмаар ион солилцох чадварыг сайжруулах зорилготой байв.

Хаягдал хөнгөн цагаан лааз: Ундааны хаягдал хөнгөн цагаан лаазыг цуглуулж, цэвэрлэн, хатааж, нунтаглан, 93-95% хөнгөн цагааны агуулгатай нэмэлт хөнгөн цагааны эх үүсвэр болгон ашигласан. Энэ нь хаягдал материалыг дахин ашиглах, судалгааны өртгийг бууруулах, мөн байгаль орчинд ээлтэй шийдлийг эрэлхийлэх зорилготой байв.

Натрийн гидроксид (NaOH): Цеолит синтезийн гидротермал процесст шүлтлэг орчин үүсгэхэд 2М-ийн NaOH уусмалыг ашигласан. NaOH нь түүхий эд дэх цахиур, хөнгөн цагааныг уусгаж, цеолит үүсэх урвалыг идэвхжүүлдэг.

Хромын уусмал: Уснаас хром шингээх туршилтад зориулж, тодорхой концентрацитай хромын уусмалыг бэлтгэсэн. Туршилтад 10 мг/л, 50 мг/л, 100 мг/л хромын уусмалуудыг ашигласан.

2.2. Цеолит синтезийн арга зүй

Шахмал түлшний үнснээс синтетик цеолит гарган авах процессыг гидротермал синтезийн аргаар гүйцэтгэсэн. Энэхүү процесс нь дараах үе шатуудаас бүрдсэн:



1. **Дээжийг нунтаглах:** Шахмал түлшний үнс, хаягдал хөнгөн цагаан лаазны нунтаг, болон нунтаг хөнгөн цагааны дээжүүдийг зохих харьцаагаар хольж, бөмбөлөгт тээрэмд 2 минут нунтагласан. Энэ нь урвалын гадаргуугийн талбайг нэмэгдүүлж, синтезийн үр ашгийг дээшлүүлэх зорилготой байв. Нунтаглах процесс нь түүхий эдийн жигд байдлыг хангаж, урвалын хурдыг нэмэгдүүлдэг.

2. **Уусмал бэлтгэх:** 2М-ийн NaOH-ийн 60 мл уусмалыг бэлтгэсэн. Энэ уусмал нь цеолит синтезийн урвалын шүлтлэг орчныг бүрдүүлдэг.

3. **Холих:** Нунтагласан дээж дээр NaOH уусмалыг нэмж, 10 минут хольж, үүссэн хөөсийг арилгасан. Энэ нь урвалын хольцыг жигд болгох, агаарыг зайлуулах, мөн урвалын эхлэлийг хангах зорилготой байв.

4. **Гидротермал синтез:** Бэлтгэсэн хольцыг автоклавт хийж, 24 цагийн турш 100°C температурт гидротермал синтезийн урвалыг явуулсан. Автоклав нь өндөр температур, даралттай нөхцөлийг бүрдүүлж, цеолитийн талстжилт явагдах боломжийг олгодог.

Хүснэгт 2.1. Туршилтын өгөгдлүүд, гаргаж авсан цеолит, үнсний хром шингээх багтаамж

#	Дээж нэрс	Үнс (гр)	SiO2 (гр)	Al2O3 (гр)	2M NaOH (мл)	H2O (мл)	Time (цаг)	Temp (°C)	Cr шингээлт (мг/г)
1	Үнс	50	-	-	-	-	-	-	0.68
2	Лааз-Al	50	46.61	2	3.39	4.8	60	24	12.60
3	Лааз-Al	50	48.53	3	1.47	4.8	60	24	9.69
4	Лааз-Al	50	49.61	4	0.39	4.8	60	24	10.73
5	Нунтаг Al	50	46.61	2	3.39	4.8	60	24	4.30
6	Нунтаг Al	50	48.53	3	1.47	4.8	60	24	9.80
7	Нунтаг Al	50	49.61	4	0.39	4.8	60	24	11.69

Тайлбар: Хүснэгт 2.1-д үзүүлсэн SiO_2, Al_2O_3-ийн хэмжээ нь нэмэлтээр оруулсан хөнгөн цагааны хэмжээг илэрхийлж байгаа бөгөөд үнсэнд агуулагдах SiO_2, Al_2O_3-ийн хэмжээг тусад нь тооцоогүй болно. Уусмалын эзлэхүүн болон хутгах хугацаа нь бүх дээжид ижил байсан.

2.3. Хром шингээх туршилтын арга зүй

Гарган авсан 6 төрлийн синтетик цеолит болон анхдагч шахмал түлшний үнсний уснаас хром шингээх чадварыг үнэлэх туршилтыг явуулсан. Туршилт нь дараах үндсэн нөхцөлүүдтэй байсан:

Хромын уусмалын концентраци: Дээж бүр дээр 10 мг/л, 50 мг/л, 100 мг/л хромын уусмалуудыг ашигласан. Эдгээр нь хромын бохирдлын янз бүрийн түвшинг загварчилсан болно.

Дээжийн жин: 0.5 грам дээжийг ашигласан. Мөн 50 мг/л хромын агуулгатай уусмалд дээжний жинг 0.1, 0.5, 1 грамаар өөрчлөн туршилт хийсэн.

Хутгах хугацаа: Дээжүүдийг хромын уусмалд 1 цагийн турш хутгалттайгаар шингээлтийн туршилт явуулсан. Мөн хугацаанаас хамааруулан 2, 10, 30, 60, 120 минут хутгаж, кинетик судалгаа хийсэн.

Шингээлт (мг/г) = (Эхлэх концентраци - Эцсийн концентраци) * Уусмалын эзлэхүүн / Дээжийн жин

Энэхүү томъёогоор дээж тус бүрийн хром шингээх багтаамжийг тодорхойлсон. Туршилтын нийт тоо 150 байсан бөгөөд үүнд 54 шингээлтийн туршилт (янз бүрийн концентрацитай), 72

дээжний гарган авах туршилт, 24 хугацаанаас хамаарах кинетик туршилт багтсан. Туршилтын дэлгэрэнгүй үр дүнг Гуравдугаар бүлэгт танилцуулна.

2.4. Шинжилгээний аргууд

Судалгааны явцад гарган авсан материалуудын химийн найрлага, эрдсийн бүтэц, болон морфологийг тодорхойлохын тулд дараах шинжилгээний аргуудыг ашигласан:

XRF (X-ray Fluorescence Spectroscopy): Шахмал түлшний үнсний элементийн шинжилгээг хийхэд ашигласан. Энэ арга нь дээжинд агуулагдах химийн элементүүдийн төрөл, агууламжийг тодорхойлдог. Үнсний XRF шинжилгээний үр дүн нь цеолит синтезлэхэд шаардлагатай цахиур, хөнгөн цагааны агууламжийг үнэлэхэд чухал мэдээлэл өгсөн.

XRD (X-ray Diffraction): Үнс болон синтезлэгдсэн цеолит дээжүүдийн эрдсийн найрлагыг тодорхойлоход ашигласан. XRD шинжилгээ нь дээжинд агуулагдах талст фазуудыг (эрдэс) тодорхойлж, тэдгээрийн бүтэц, талстын хэмжээ зэрэг мэдээллийг өгдөг. Энэ нь үнсийг цеолит болгон хувиргасан эсэхийг баталгаажуулах, мөн үүссэн цеолитийн төрлийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэсэн.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ҮР ДҮН, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү бүлэгт шахмал түлшний үснээс синтетик цеолит гарган авах, мөн гарган авсан цеолитуудын уснаас хром шингээх чадварыг судлах зорилготой туршилтуудын үр дүнг танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлнэ. Үр дүнгүүдийг XRF, XRD шинжилгээний мэдээлэл, болон хромын шингээлтийн туршилтын үр дүнгүүд дээр үндэслэн тайлбарлав.

3.1. Шахмал түлшний үнсний шинж чанар

